

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНГИЙН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2010 оны ᠒᠘ сарын 11 өдөр

Дугаар 475/182

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

"Төв банк /Монголбанк/-ны тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 1 дэх заалтын 2 дахь хэсэг, "Банкны тухай хууль"-ийн 35 дугаар зүйлийн 6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг 2010 оны 8 дугаар сарын 1᠘-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Дараахь нөхцлийн аль нэгийг хангасан, зээлийн гэрээний анхны нөхцөл 2010 оны 7-р сарын 1-нээс өмнө өөрчлөгдсөн зээлийг журмын 2.9-т заасан анхны нөхцөл өөрчлөгдсөн зээлд тооцохгүй байсугай:
 - 1) анхны гэрээгээр зээл олгосон өдрөөс төлөгдөж дуусах өдөр хүртэлх хугацаа нэг жилээс ихгүй ба зээл сунгасан гэрээгээрх зээлийн төлөгдөх өдөр хүртэлх хугацаа анхны гэрээгээрх хугацаанаас хэтрэхгүй,
 - 2) анхны гэрээгээр зээл олгосон өдрөөс төлөгдөж дуусах өдөр хүртэлх хугацаа нэг жилээс их ба зээл сунгасан гэрээгээрх зээлийн төлөгдөх өдөр хүртэлх хугацаа анхны гэрээгээрх хугацааны 50 хувиас хэтрэхгүй.
4. Дараахь нөхцлийн аль нэгийг хангасан, зээлийн гэрээний анхны нөхцөл 2010 оны 7-р сарын 1-нээс өмнө өөрчлөгдсөн зээлийг дараахь байдлаар тооцож ангилсугай:
 - 1) анхны гэрээгээр зээл олгосон өдрөөс төлөгдөж дуусах өдөр хүртэлх хугацаа нэг жилээс ихгүй ба зээл сунгасан гэрээгээрх зээлийн төлөгдөх өдөр хүртэлх хугацаа анхны гэрээгээрх хугацаанаас их бол тухайн зээлийн төлөгдөж дуусах өдрийг анхны гэрээгээрх хугацаатай тэнцүүгээр тооцно.
 - 2) анхны гэрээгээр зээл олгосон өдрөөс төлөгдөж дуусах өдөр хүртэлх хугацаа нэг жилээс их ба зээл сунгасан гэрээгээрх зээлийн төлөгдөх өдөр хүртэлх хугацаа анхны гэрээгээрх хугацааны 50 хувиас их бол тухайн зээлийн төлөгдөж дуусах өдрийг анхны гэрээгээрх хугацааны 50 хувьтай тэнцүүгээр тооцно.
5. Журмын 2.12, 2.16 дахь заалтыг 2010 оны 7-р сарын 1-нээс өмнө олгогдсон зээлийн хувьд 2011 оны 1-р сарын 1-нээс эхлэн дагаж мөрдсүгэй.
6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2004 оны 459/207 тоот, 2006 оны 147/94 тоот, 2009 оны 125/50 тоот хамтарсан тушаалуудыг хүчингүй болгосугай.

7. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг банкуудын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал нарт даалгасугай.

8. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Хяналт шалгалтын газар (Б.Лхагвасүрэн), Сангийн Яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын газар (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ
Д.ПҮРЭВДОРЖ

САНГИЙН САЙД
С.БАЯРЦОГТ

**АКТИВЫГ АНГИЛАХ, АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛЖ,
ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл



1.1 Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 5, 6 дахь заалт, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн банк, банк бус санхүүгийн байгууллага (цаашид “зээлдүүлэгч” гэх) нь зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив (цаашид “зээл” гэх), батлан даалт, баталгаа, аккредитив болон бусад хүлээж болзошгүй үүрэг (цаашид “хүлээж болзошгүй үүрэг” гэх), Монголбанкны үнэт цаас, 1 жил хүртэлх хугацаатай Засгийн газрын үнэт цаас, Банкны бүтцийн өөрчлөлтийн өрийн бичгээс бусад үнэт цаас (цаашид “үнэт цаас” гэх), овердрафт, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө, авлага, авлагатай адилтгах бусад актив (цаашид “бусад актив” гэх)-ыг ангилах, зээл, үнэт цаас төлөгдөх, авлага барагдахад болон хүлээж болзошгүй үүргийг хэрэгжүүлсэнээр учирч болзошгүй алдагдлаас хамгаалах эрсдэлийн санг байгуулж, зарцуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Зээлдүүлэгч нь зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад активын хугацааны ба чанарын үзүүлэлтийг энэ журмын хавсралтад заасан хүчин зүйлсээр тооцон ангилж, эрсдэлийн санг байгуулна.

1.3 Зээлдүүлэгч нь дотооддоо активын эрсдэлийн үнэлгээ хийж, тухайн үнэлгээний дагуу активын эрсдэлийн санг байгуулж болох ба ийнхүү байгуулсан активын эрсдэлийн сан нь энэ журмын дагуу байгуулах эрсдэлийн сангаас багагүй байна.

1.4 Зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад активын эрсдэлийн санг энэ журамд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

1.5 Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

1.5.1 “хүлээж болзошгүй үүрэг” гэж “Банкны нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн журам”-ын 5 дугаар бүлгийн 1-д тодорхойлсныг;

1.5.2 “актив” гэж зээлдүүлэгчид зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад актив хэлбэрээр үүссэн өр төлбөрийг,

1.5.3 “төлбөр хариуцагч” гэж зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад активыг

зээлдүүлэгчид төлж барагдуулах үүрэг хүлээсэн этгээдийг,

1.5.4 "овердрафт" гэж харилцагч тодорхой хязгаарын хүрээнд дансны үлдэгдлээсээ илүү хэмжээний мөнгө данснаасаа авсан үед бий болох богино хугацаат зээлийг.

ХОЁР. Активыг ангилах

2.1 Зээлдүүлэгч нь зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад активыг дор дурдсан байдлаар ангилж, хугацааны болон чанарын үзүүлэлтэд орсон өөрчлөлтийг тухай бүр тооцож, ангиллыг тухайн сард 2 удаа хийнэ:

[/Дээрх 2.1 дэх заалтыг МБЕ, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр хамтарсан тушаалаар өөрчлөн найруулсан/](#)

2.1.1 Хэвийн;

2.1.2 Хугацаа хэтэрсэн;

2.1.3 Чанаргүй, үүнээс:

2.1.3.а хэвийн бус;

2.1.3.б эргэлзээтэй;

2.1.3.в муу.

2.2 Зээлдүүлэгч нь өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс бусад активыг хугацааны болон чанарын үзүүлэлтээр үнэлж, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг зөвхөн хугацааны үзүүлэлтээр ангилна. Ингэхдээ хугацааны үзүүлэлтээр ангилсны дараа чанарын үнэлгээг хийж ангиллыг тодорхойлно. Санхүүгийн тайлан гаргах бололцоогүй төлбөр хариуцагчийн хувьд чанарын үнэлгээг 1в дүгээр хавсралтын 1 болон 3 дугаар хэсэгт заасны дагуу хийж, нийт оноог 2-оор үржүүлэн чанарын хүчин зүйлсийн нэгдсэн үнэлгээг тодорхойлно.

2.3 Хугацааны үзүүлэлтийг 1а, 1б, 2а, 3а болон 4а дугаар хавсралтад заасны дагуу тооцож, активыг ангилна.

2.4 Активын чанарын үзүүлэлтийг 1в дүгээр хавсралтад заасан хүчин зүйлс тус бүрээр тооцно.

2.5 Активын ангиллыг тогтоохдоо чанарын хүчин зүйлсийн нэгдсэн үнэлгээг гаргана. Чанарын нэгдсэн үнэлгээний дүн нь 50 онооноос хэтрэхгүй. Чанарын нэгдсэн үнэлгээ нь 45-50 оноотой байгаа тохиолдолд хугацааны ангиллыг өөрчлөхгүй. Харин энэхүү чанарын нэгдсэн үнэлгээ нь 30-44 оноотой байгаа тохиолдолд хугацааны ангиллыг нэг шатаар, 0-29 оноотой байгаа тохиолдолд хугацааны ангиллыг хоёр шатаар тус тус бууруулна.

2.6 Төлбөр хариуцагчийн төлбөрийн чадвар алдагдсан, дампуурсан үед барьцаанд тавьсан эд хөрөнгийн тухайн үеийн үнэлгээ нь активын үндсэн өр болон хүүгийн 75-аас доошгүй хувийг төлж барагдуулахад хангалттай тохиолдолд эргэлзээтэй ангилалд, хангалтгүй тохиолдолд муу ангилалд хугацаа харгалзалгүй ангилна.

2.7 Зээлдүүлэгч нь активын чанарын үзүүлэлтийг тооцохын тулд тухайн байгууллагын санхүүгийн тайланг улирал болгон гаргуулан авч судалгаа тооцоо хийх бөгөөд санхүүгийн тайланг оны эцэст аудитаар баталгаажуулсан байх шаардлагыг тавина.

2.8 Хууль хяналтын байгууллагаар гэмт хэргийн шинж чанартай үйлдлээс үүссэн байж болзошгүй шалтгаанаар шалгагдаж байгаа активт 100 хувь эрсдэлийн сан байгуулна.

2.9 [/Энэ заалтыг МБЕ, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр хамтарсан тушаалаар хүчингүй болгосон/](#)

2.10 [/Энэ заалтыг МБЕ, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр хамтарсан тушаалаар хүчингүй болгосон/](#)

2.11 Активын гэрээний хугацааг 1 (нэг) удаа сунгасан бол ангиллыг хэвээр хадгална, харин 2 (хоёр) дахь удаагаа сунгавал уг активыг одоо байгаа ангиллаас нэг шатлалаар бууруулна.

[/Дээрх 2.11 дэх заалтыг МБЕ, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр хамтарсан тушаалаар өөрчлөн найруулсан/](#)

2.12 Зээлдүүлэгч төлбөр хариуцагч, түүний холбогдох этгээдийн активын ангиллыг тухайн зээлдүүлэгч дэх төлбөр хариуцагч, түүний холбогдох этгээдийн бусад өр төлбөр буюу актив болон бусад банкин дахь актив чанаргүйд ангилагдсан тохиолдолд дахин хийнэ. Ийнхүү дахин хийсэн ангиллыг тухайн төлбөр хариуцагчийн тухайн болон бусад зээлдүүлэгчид буй хамгийн доод ангилалтай активаас нэг ангилал дээгүүр ангиллаас дээр байхаар хийхгүй.

2.13 Банк хоорондын захаар дамжуулан баталгаа гаргах, эх үүсвэр байршуулан хуйвалдах замаар актив үүсгэсэн бөгөөд тухайн активын хугацааны болон чанарын үзүүлэлт, энэ журмын бусад заалтын дагуу хэвийн болон хугацаа хэтэрсэн ангилалд байгаа тохиолдолд тухайн активыг хэвийн бус ангилалд ангилна.

2.14 Ангилал буурсан активыг зөвхөн үндсэн өр болон хүүгийн эргэн төлөлт нь ангилал буурсны дараа нэг жилээс доошгүй хугацаанд хуваарийн дагуу хийгдсэн ба энэхүү хугацааг ангилал буурсан өдрөөс төлөгдөж дуусах өдөр хүртэлх хугацаанд харьцуулсан хувиас багагүй хэмжээгээр ангилал буурсны дараа төлөгдөх үндсэн өр болон хүүгийн нийт дүнгээс төлөгдсөн тохиолдолд тухайн активыг ангилал дээшлүүлэн бүртгэж болно.

2.15 Банкууд нэг төслийг хамтран зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг хэлбэрээр санхүүжүүлсэн тохиолдолд тухайн зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүргийн хяналтыг аль нэг банк нь дангаараа хэрэгжүүлж болох ба энэ тухай холбогдох гэрээнд тодорхой заасан байна.

2.16 “Банкны тухай хууль”-ийн 17.3-т заасан хязгаарлалтыг банк зөрчсөн тохиолдолд банкнаас холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэрийн хуульд заасан хязгаарлалтаас хэтэрсэн дүн болон нэг холбогдох этгээдүүдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын хуульд заасан хязгаарлалтаас хэтэрсэн дүнгийн нийлбэрийн аль ихээр эрсдэлийн санг зардлаар байгуулна. Энэхүү эрсдэлийн сан байгуулах дүнг тодорхойлоход ашиглах “Банкны тухай хууль”-ийн хязгаарлалтыг тооцохдоо энэ журамд заасан бусад эрсдэлийн сан байгуулах болон өөрийн хөрөнгийн холбогдох бусад тохиргоог хийсний дараахь өөрийн хөрөнгөд үндэслэнэ.

2.17 Банк нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд ирүүлэх зээлдэгчийн талаарх мэдээлэлдээ тухайн активын ангилал, түүний өөрчлөлтийг журмын 2.1 дэх хэсэгт заасан давтамжийн дагуу үнэн зөв тусгасан байна.

[/Дээрх 2.17 дахь заалтыг МБЕ, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр хамтарсан тушаалаар өөрчлөн найруулсан/](#)

2.18 Төлбөр хариуцагчийн санхүүгийн чадвар муудсан болон анхны гэрээ, хэлцлийн дагуу төлбөр хийх чадваргүй болсноос шалтгаалан актив төлөгдөх хугацааг сунгасан, банкнаас төлбөрийг нь төлүүлэхээр хууль хяналтын байгууллагад нэхэмжлэл гаргасан байгаа активт энэ журмын 2.11 дэх хэсэг хамаарахгүй.

[/Дээрх 2.18 дахь заалтыг МБЕ, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр хамтарсан тушаалаар нэмсэн/](#)

2.19 Журмын 2.1 заасан активт ангилал хийх давтамжийг тухайн сарын 15-ны өдөр болон сарын сүүлийн өдрөөр тогтоох бөгөөд эдгээр өдөр нь нийтээр амрах баярын өдөр болон 7 хоног бүрийн амралтын өдөр таарвал, ангилал хийх хугацааг тухайн хугацааны өмнөх ажлын өдөр холбогдох ангиллыг хийнэ.

[/Дээрх 2.19 дэх заалтыг МБЕ, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр хамтарсан тушаалаар нэмсэн/](#)

ГУРАВ. Активын эрсдэлийн санг байгуулах, зарцуулах

3.1 Зээлдүүлэгч активын эрсдэлийн санг энэ журмын 3.2-т заасан хувь хэмжээгээр зардлаар байгуулна.

3.2 Активын ангилалд эрсдэлийн санг актив тус бүрийн үлдэгдэл дүнгээс дор заасан хувь хэмжээгээр байгуулна. Үүнд:

3.2.1 Хэвийн ангилалд 1 хувь;

[/Дээрх 3.2.1 дэх заалтыг МБЕ, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр хамтарсан тушаалаар өөрчлөн найруулсан/](#)

3.2.2 Хугацаа хэтэрсэн ангилалд 5 хувь;

3.2.3 Чанаргүй ангилалтай актив, үүнээс:

3.2.3.а хэвийн бус ангилалд 25 хувь;

3.2.3.б эргэлзээтэй ангилалд 50 хувь;

3.2.3.в муу ангилалд 100 хувь.

3.3 Активыг ангилж сан байгуулахдаа дараахь үндсэн зарчмыг баримтална. Үүнд:

3.3.1 Хэвийн активыг санхүүгийн тайлан тэнцэлд анх тусгах үед эрсдэлийн санг 1 хувиар байгуулна. Харин активтай холбоотой гэрээ, хэлцлийн дагуу үүрэг хүлээсэн этгээд нь үндсэн өр болон хүүгийн төлбөрийг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаан төлөх чадваргүй болж болзошгүй нь үндэслэл бүхий баримтаар нотлогдсон бол зээлдүүлэгч нь хүлээж болзошгүй алдагдлын дүнг тухай бүр тооцож, холбогдох эрсдэлийн санг журмын 2.1-д заасан давтамжийн дагуу зардлаар байгуулна.

/Дээрх 3.3.1 дэх заалтыг МБЕ, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр хамтарсан тушаалаар өөрчлөн найруулсан/

3.3.2 Банк эрсдэлийн сан байгуулах, зориулалтын дагуу ашиглах, эрсдэлийн сангаас зарцуулах гүйлгээг Монголбанкнаас тогтоосон нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу хийнэ.

3.3.3 Активын хэлбэрийг өөрчилсөн тохиолдолд хэлбэр өөрчлөгдөхөөс өмнөх ангиллыг хэвээр хадгалж, түүнд үндэслэн энэхүү журмын дагуу дараагийн ангиллыг хийнэ.

3.3.4 Хувьцаа болон түүнтэй адилтган тооцох үнэт цаас нь арилжааны бус дансанд бүртгэлтэй бол эрсдэлийн санг тухайн үнэт цаасны анх худалдан авсан үнэ болон тайлант үеийн зах зээлийн үнэ хоёрын зөрүүгээр тооцно.

3.3.5 1в хавсралтын 1.1, 1.3, 1.4, 1.5.1, 1.5.2, 1.5.3 болон 1.6-д заасан баримтуудын аль нэг нь байхгүй байгаа тохиолдолд уг хавсралтад заасан активын хувийн хэргийн бүрдлийн чанарын үзүүлэлтүүдэд 0 оноо өгнө.

3.3.6 Дараахь нөхцөл байдал үүссэн тохиолдолд 1в хавсралтад заасан төлбөр хариуцагчийн санхүүгийн үзүүлэлтүүдэд өгөх оноог 19-өөс хэтрүүлж болохгүй:

3.3.6.а Уг хавсралтад 2.1.2 болон 2.4.1-д заасан харьцаануудын аль нэг нь нэгээс бага байгаа;

3.3.6.б Уг хавсралтын 2.1.1, 2.1.2, 2.2.3, 2.3.1 болон 2.4.1-д заасан харьцаануудын аль нэг нь өмнөх үеийн үзүүлэлтээсээ 30-аас дээш хувиар буурсан;

3.3.6.в Уг хавсралтын 2.1.5-д заасан үзүүлэлт нь сөрөг утгатай байгаа;

3.3.7. Энэхүү журмын 1в хавсралтын 2.1.2 ба 2.1.4-т заасан харьцаануудын аль нэг нь эерэг бус утгатай байгаа бол төлбөр хариуцагчийн санхүүгийн үзүүлэлтүүдэд өгөх оноог 4-өөс хэтрүүлж болохгүй.

3.3.8 Дараахь нөхцөл байдал үүссэн тохиолдолд 1в хавсралтад заасан бусад

чанарын үзүүлэлтүүдэд өгөх оноог 9-өөс хэтрүүлж болохгүй:

3.3.8.а Активын барьцаанд тавьсан барьцааны зүйлийн захиран зарцуулах эрх зээлдүүлэгчид бүрэн шилжиж ирээгүй;

3.3.8.б Активт батлан даалт гаргасан этгээд нь төлбөрийн чадваргүй болсон;

3.3.8.в Олон улсад нэр хүнд бүхий мэргэжлийн байгууллагаас тухайн зээлдэгчид ССС+ (Стандарт энд Пуурс компаний буюу түүнтэй адилтган тооцох аргачлалаар) буюу түүнээс доош зэрэглэл тогтоосон.

3.4 Зээлдүүлэгч нь активын ангиллыг өөрчлөгдөх тухай бүрт эрсдэлийн санг энэ журмын 3 дугаар бүлгийн 2-т заасан хувь хэмжээгээр байгуулах бөгөөд дутуу байгуулсан санг нэмж байгуулах тохиолдолд зээлдүүлэгч зардлаар нэмж байгуулах, илүү байгуулсан санг буцаах тохиолдолд эхэлж сан байгуулсан зардлын дансыг хорогдуулах бөгөөд илүү байгуулсан дүн нь тухайн үед байгаа зардлын дансны үлдэгдлээс хэтэрсэн нөхцөлд бусад орлогын дансанд хаана.

3.5 Зээлдүүлэгч активыг холбогдох сангаас зөвхөн дор дурьдсан нөхцөлд дараахь баримт бичгийг үндэслэн хорогдуулж болно:

3.5.1 Төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарснаас хойш 180 хоногийн дотор төлбөр хариуцагчаас төлбөрийг бүрэн хийгээгүй нөхцөлд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр;

3.5.2 Төлбөр хариуцагчаас тодорхой хэсгийг гаргуулахаар шүүхийн шийдвэр гарсан боловч үлдэх хэсгийг төлбөр хариуцагч хариуцахгүй болсныг тогтоосон шүүхийн шийдвэрээр тухайн үлдэх хэсгийг;

3.5.3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тухай шүүгчийн захирамж болон ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор;

3.5.4 Төлбөр хариуцагчийн талаар шүүхэд хандсан боловч тодорхой шийдвэр гаргах боломжгүй нөхцөл бий болсон активыг муу ангилалд орсноос хойш хагас жилийн дараа өөрийн хөрөнгийн 1 хувь хүрэхгүй дүнтэй активыг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр, өөрийн хөрөнгийн 1 хувиас доошгүй дүнтэй активыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр.

3.6 Зээлдүүлэгч тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүргийг зээлтэй адилтган ангилж, энэхүү журмын 3.2-т заасан хувь хэмжээгээр эрсдэлийн санг байгуулж, зээлийн эрсдэлийн сангийн дансанд нэрийн данс нээж бүртгэнэ.

3.7 Зээлдүүлэгчийн хувь нийлүүлэгчийн хувьд энэ журмын 3.5.1 дэх заалт хамаарахгүй бөгөөд тухайн зээлдүүлэгч дэх активаа төлж чадахгүй бол эхний ээлжинд

барьцаа хөрөнгийг худалдаж орсон орлогоор, хэрэв үндсэн өр төлбөр, хүүгийн дүн уг орлогоос давж байвал, тухайн зээлдүүлэгчид хувь нийлүүлсэн хөрөнгийг худалдаж, орсон орлогоор активыг төлүүлнэ.

3.8 Зээл, үнэт цаас, бусад активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тохиолдолд тэнцлийн гадуурх дансанд /хувийн хэрэг болон холбогдох бусад бичиг баримтын хамтаар/ бүртгэж, төлүүлж барагдуулах арга хэмжээг эрчимтэй үргэлжлүүлнэ.

3.9 Сангаар хорогдуулж тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн зээл, үнэт цаас, бусад активын төлбөр хийгдсэн нөхцөлд тэр хэмжээгээр зээлдүүлэгчийн үйл ажиллагааны бусад орлогод бүртгэнэ.

3.10 Банк активын ангилал хийж, эрсдэлийн санг байгуулсан талаарх сар бүрийн тайланг дараа сарын 5-ны дотор 5а хавсралтын дагуу Монголбанкны Хяналт шалгалтын газарт бичгээр болон файлаар ирүүлнэ.

ДӨРӨВ. Хяналт, хариуцлага

4.1 Зээлдүүлэгч байгууллагын удирдлага нь актив хөрөнгийн эрсдэлийг хянаж, удирдах зохистой механизмыг бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

4.2 Активын эрсдэлийг тэдгээрийн хугацаа, чанарын үзүүлэлтийг харгалзан өөрчлөлт орох тухай бүрт тооцож, энэ журамд заасан хувь хэмжээг үндэслэн эрсдэлийн санг байгуулсан байдал, сангийн зарцуулалтад тухайн зээлдүүлэгчийн Дотоод аудит хариуцсан нэгж хяналт тавьж, Төлөөлөн удирдах зөвлөлдөө тайлагнаж байна.

[/Дээрх 4.2 дахь заалтыг МБЕ, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр хамтарсан тушаалаар өөрчлөн найруулсан/](#)

4.3 Монголбанк энэ журмын 3.2-т заасан эрсдэлийн сангийн хувь хэмжээг нэмэгдүүлэн тогтоож болно. Эрсдэлийн санг энэ журамд заасан хэмжээнээс нэмэгдүүлэн байгуулах тохиолдолд үндэслэлийг тогтоож, баримтаар баталгаажуулна.

4.4 Монголбанк нь тухайн банкны удирдлага активын эрсдэлийг хэрхэн үнэлж, дүгнэн ангилж, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах талаар авч байгаа арга хэмжээ нь зохистой эсэх, ангиллыг үнэн зөв хийж байгаа эсэх, эрсдэлийн санг бүрэн байгуулж байгаа байдлыг газар дээр нь шалгаж, зайнаас хяналт тавина.

4.5 Монголбанк нь банкны удирдлага, Дотоод аудит хариуцсан нэгж, Зээлийн хороо, Актив пассивын хороо хэрхэн ажиллаж байгааг шалгах явцад активыг энэ журмын дагуу ангилаагүй, холбогдох санг тогтоосон хувь хэмжээгээр байгуулаагүй, буруу зарцуулсан нөхцөлд банк, түүний удирдлага, холбогдох ажилтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

1а хавсралт

Зээлийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус зээл	Эргэлзээтэй зээл	Муу зээл
Хугацааны үзүүлэлт	Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт, хуваарьт заасан хугацаандаа хийгдэж байгаа.	Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 90 хүртэл хоног хэтэрсэн.	Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 91-180 хоног хэтэрсэн.	Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 181-360 хоног хэтэрсэн.	Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 361-ээс дээш хоног хэтэрсэн.

1б хавсралт

Овердрафт болон эргэн төлөгдөх хуваарийг урьдчилан тогтоогоогүй бусад зээлүүдийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу зээл
Хугацааны үзүүлэлт	Өр төлбөр хугацаандаа төлөгдөж байгаа.	Өр төлбөр төлөгдөх хугацаанаас 90 хүртэл хоног хэтэрсэн.	Өр төлбөр төлөгдөх хугацаанаас 91-180 хоног хэтэрсэн.	Өр төлбөр төлөгдөх хугацаанаас 181-360 хоног хэтэрсэн.	Өр төлбөр төлөгдөх хугацаанаас 361-с дээш хоног хэтэрсэн.

2а хавсралт

Үнэт цаасыг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт, хуваарьт заасан хугацаандаа төлөгдөж байгаа.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 30 хүртэл хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 31-60 хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 61-90 хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 91-ээс дээш хоног хэтэрсэн.

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Өмчлөлд авснаас хойш 30 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 31-60 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 61-90 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 91-120 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 121 хоногоос дээш хугацаанд борлогдоогүй

Бусад активыг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	30 хүртэл хоногийн дотор байгаа	31-60 хоногийн дотор төлөгдөөгүй	61-90 хоногийн дотор төлөгдөөгүй	91-120 хоногийн дотор төлөгдөөгүй	121-ээс дээш хоногоор төлөгдөөгүй буюу ашиглан, гэмт хэргийн улмаас бий болсон авлага

ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААС, ХҮЛЭЭЖ БОЛЗОШГҮЙ ҮҮРГИЙН, ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ДҮГНЭХ ХҮСНЭГТ

ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД		ОНОО
1.Активын хувийн хэргийн бүрдэл	1.1.Тухайн зээлдүүлэгчийн мөрдөж буй дотоод дүрэм, журмын дагуу шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр бий эсэх, төлбөр хариуцагчийн талаарх зээлдүүлэгчийн дүгнэлт 1.2. Зээл олгохыг хүссэн өргөдөл 1.3. Активын төлбөр болон холбоотой бусад гэрээ, гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт 1.4.Төлбөр хариуцагчийн анкет, дүрэм, үүсгэн байгуулсан гэрээ, улсын бүртгэлийн гэрчилгээ 1.5. Барьцаа хөрөнгийн: 1.5.1 Тодорхойлолт 1.5.2 Үнэлгээний баримт бичиг 1.5.3 Үл хөдлөх хөрөнгө бол улсын бүртгэлийн гэрчилгээ 1.5.4 Шалгасан баримт 1.6. Батлан даалт болон барьцааны гэрээ 1.7. Зээл, хүлээж болзошгүй үүрэг, үнэт цаас, бусад актив хэлбэрээр санхүүжигдэх санхүүжигдэх төсөл 1.7.1 Шаардлагатай бол эрх бүхий байгууллагаар батлуулсан эсэх 1.7.2 Үйл ажиллагааны талаарх баримт бичиг 1.7.3 Төсөлд орсон өөрчлөлт 1.7.4 Төсөлтэй холбоотой төлбөр тооцооны баримт бичиг 1.7.5 Төсөл	10

	болон төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 1.7.6 Холбогдох гэрээ 1.7.7 Активыг төлөх эх үүсвэрийн тооцоо 1.8. Санхүүгийн тайлан 1.9. Активын ашиглалт шалгасан материал 1.10. Зээлдэгчийн талаар холбогдох мэдээллийн сангуудаас авсан мэдээлэл	
2.Төлбөр хариуцагчийн санхүүгийн үзүүлэлтүүд	2.1 Төлбөрийн чадвар 2.1.1 Эргэлтийн хөрөнгө /Богино хугацаат өр төлбөр 2.1.2 (Мөнгөн хөрөнгө+Богино хугацаат хөрөнгө оруулалт+Авлага)/Богино хугацаат өр төлбөр 2.1.3 Нийт орлого /Авлага 2.1.4 Эзэмшигчдийн өмч/ Хөрөнгө 2.1.5 Үндсэн үйл ажиллагаанаас хангалттай мөнгөн орлого олж байгаа эсэх 2.2 Ашигт ажиллагаа 2.2.1 Нийт ашиг /Нийт орлого 2.2.2 Нийт зардал/нийт орлого 2.2.3 Активын өгөөж 2.2.4 Активын өгөөжийн хэлбэлзэл 2.2.5 Эзэмшигчдийн өмчийн өгөөж 2.3 Хөрөнгийн удирдлага 2.3.1 Авлагын эргэлт /дундаж/ 2.3.2 Авлагын эргэлт /тайлант үеийн эцэст/ 2.3.3 Бараа материалын эргэлт /дундаж/ 2.3.4 Бараа, материалын эргэлт /тайлант үеийн эцэст/ 2.3.5 Үндсэн хөрөнгийн эргэлт 2.3.6 Нийт активын эргэлт 2.4 Өрийн удирдлага 2.4.1 Татвар болон хүү төлөхийн өмнөх ашиг /Хүүгийн зардал 2.4.2 Нийт өр төлбөр /Хөрөнгө 2.4.3 Богино хугацаат өр төлбөр/ Нийт өр төлбөр	25
3. Бусад	3.1 Барьцаа болон батлан даалт 3.1.1 Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь активын үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хангалттай эсэх 3.1.2 Барьцаа хөрөнгийн захиран зарцуулах эрх нь зээлдүүлэгчид бүрэн шилжиж ирсэн эсэх 3.1.3 Актив нь гуравдагч этгээдээс гаргасан батлан даалттай эсэх 3.1.4 Актив нь батлан даалттай бол батлан даагч нь төлбөрийн чадвар сайтай эсэх 3.2 Зээлийн мэдээллийн сангаас авсан мэдээлэл 3.2.1 Хугацаа хэтэрсэн ямарваа нэгэн зээлийн болон бусад хэлбэрийн өртэй эсэх 3.2.2 Төлбөр хариуцагчийн түүх 3.3 Бусад мэдээлэл 3.3.1 Зэрэглэл тогтоогч байгууллагаас авсан мэдээлэл 3.3.2 Аудитын компаниас авсан мэдээлэл 3.3.3 Бусад (төрийн ба төрийн бус байгууллага, нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл) 3.3.4 Эдийн засгийн болон зээлдэгчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын ерөнхий төлөв байдал	15
		50

АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ТАЙЛАН

Зээл		(мянган төгрөгөөр)			
		Зээлийн өрийн үлдэгдэл	Монголбанкны журмын дагуу байгуулсан сан	Банкны байгуулсан сан	Илүү (+), дутуу(-)
1	Хэвийн				
2	Хугацаа хэтэрсэн				
3	Чанаргүй а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Муу				
4	Нийт (1+2+3)				

Үнэт цаас		(мянган төгрөгөөр)			
		Үнэт цаасны дүн	Монголбанкны журмын дагуу байгуулсан сан	Банкны байгуулсан сан	Илүү (+), дутуу(-)
1	Хэвийн				
2	Хугацаа хэтэрсэн				
3	Чанаргүй а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Муу				
4	Нийт (1+2+3)				

ӨБҮХХ		(мянган төгрөгөөр)			
		Хөрөнгийн дүн	Монголбанкны журмын дагуу байгуулсан сан	Банкны байгуулсан сан	Илүү (+), дутуу(-)
1	Хэвийн				
2	Хугацаа хэтэрсэн				
3	Чанаргүй а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Муу				
4	Нийт (1+2+3)				

Овердрафт болон бусад актив		(мянган төгрөгөөр)			
		Үлдэгдэл дүн	Монголбанкны журмын дагуу байгуулсан сан	Банкны байгуулсан сан	Илүү (+), дутуу(-)
1	Хэвийн				
2	Хугацаа хэтэрсэн				
3	Чанаргүй а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Муу				
4	Нийт (1+2+3)				

Тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа хүлээж болзошгүй үүрэг

(мянган төгрөгөөр)

		Хүлээж болзошгүй үүргийн дүн	Монголбанкны журмын дагуу байгуулсан сан	Банкны байгуулсан сан	Илүү (+), дутуу(-)
1	Хэвийн				
2	Хугацаа хэтэрсэн				
3	Чанаргүй а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Муу				
4	Нийт (1+2+3)				

Холбогдох этгээдэд олгсон зээл, зээлтэй адилтган тооцох актив
хөрөнгө, баталгаа, батлан даалт

(мянган төгрөгөөр)

		Үлдэгдэл дүн	Монголбанкны журмын дагуу байгуулсан сан	Банкны байгуулсан сан	Илүү (+), дутуу(-)
1	Холбогдох этгээдэд олгсон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтад байгуулсан сан				

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын захирал

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/